



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д. Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026. 08. 17 № ХЭГ/2779
танай _____-ны № _____-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д заасан хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжтэй холбоотой Танаас ирүүлсэн асуулгын хүрээнд дараах мэдээллийг хүргүүлж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлд хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжийг нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч нэг удаа олгохоор хуульчилсан. Ажилтанд олгох тэтгэмжийн доод хэмжээг тухайн аж ахуйн нэгж, байгууллагад ажилласан жилээс хамааруулан 1-4 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээтэй байхаар заасан бөгөөд хэрэв уг тэтгэмжийн хэмжээг дээшлүүлэн тогтоох бол хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр шийдвэрлэх зохицуулалттай.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах тухай" 158 дугаар конвенцид хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжийг тухайн байгууллагад ажилласан хугацааг харгалзан үндэсний хууль тогтоомжоор зохицуулахаар заасан байдаг. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын гишүүн 100 гаруй улс оронд ажил олгогчоос олгох хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжийг ажилласан жилтэй нь уялдуулсан хууль тогтоомж үйлчилж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, багц хуулийн төсөл боловсруулахад түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлсон байдаг.

Дээрх хуулийн 51.3-т "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно" гэж заасны дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх ажлыг энэ онд багтаан хийхээр төлөвлөж байна.

000265008285

Монгол Улсын Засгийн газраас төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зохион байгуулалтын бүтцийг оновчтой болгох, удирдах, гүйцэтгэх албан тушаалын зохистой харьцааг хангаж чиг үүргийн давхардлыг арилгах, төрийн байгууллагын үйл ажиллагааны шат дамжлагыг цөөлөх, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлийг баримтлан холбогдох ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж, тодорхой үр дүнд хүрч байна. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар 29-ний өдрийн 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”-д “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх” зорилт тусгагдсан. Уг зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголд багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулах зохицуулалтыг тусган хэрэгжүүлснээр төрийн албан хаагчдын тоо 2024 онд 226,895 байсан бол 2025 онд 213,611 болж нийт 13,284-өөр буураад байна.

2. Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 16 яамдын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан. Яамдын 142 газар, 147 хэлтэс, албаны тоог цөөрүүлж, 114 газар, 95 хэлтэс, албатай болгосноор газрын даргын орон тоо 28-аар буюу 19.7 хувиар, хэлтсийн даргын орон тоо 53-аар буюу 36.5 хувиар тус тус буурсан. Орон тооны дээд хязгаар 1980 байсныг 1812 болгож, нийт орон тоог 168-аар буюу 8.5 хувиар бууруулсан.

3. Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар тогтоолоор 35 агентлагийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталж, 148 газар, 173 хэлтэс, албатай байсныг цөөрүүлж, 118 газар, 149 хэлтэстэй болгосон. Ингэснээр газрын даргын орон тоо 30-аар буюу 20.0 хувиар, хэлтэс, албаны даргын орон тоо 24-өөр буюу 14 хувиар тус тус буурсан. Орон тооны дээд хязгаар 3353 байсныг 3061 болгож, нийт орон тоог 292-оор буюу 8.7 хувиар бууруулсан. Мөн Засгийн газрын агентлагийн харьяа аймаг, нийслэл дэх байгууллага, бүтцийн нэгжийн тоо 906 байсныг 75-аар бууруулж 831 болгож, нийт орон тоо 14,300 байсныг 1161-ээр бууруулж 13,139 болгосон.

4. Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Зарим үндэсний хороо, зөвлөлийг татан буулгах тухай” 22 дугаар тогтоолоор хуулиар чиг үүргийг нь тухайлан заагаагүй болон хуульд тусгайлан заасан ч чиг үүргийн давхардал үүсгэж байсан 29 үндэсний хороо, зөвлөлийг татан буулгаж, ажлын албаны орон тоог 146-аар бууруулсан.

5. Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Төрийн өмчийн хуулийн этгээдийн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулах, шинэчлэх талаар авах арга хэмжээний тухай” 61 дүгээр тогтоолоор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн чиг үүргийн давхардлыг арилгах, зохион байгуулалтын бүтцийг оновчтой тогтоох замаар орон тоог 10-аас доошгүй хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардлыг 15-аас доошгүй хувиар бууруулахыг холбогдох албан тушаалтанд үүрэг болгосон. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Эрдэнэс Монгол” ХХК 2026 онд чиг үүргийн шинжилгээ хийж, зохион байгуулалтын бүтцээ өөрчилж, давхардсан орон тоогоо 10 хувиар бууруулсан байна.

6.Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн ““Эрдэнэс Монгол” нэгдлийн шинэчлэл, бүтцийн өөрчлөлтийн талаар авах арга хэмжээний тухай” 251 дүгээр тогтоолыг баталсан. Энэ тогтоолын хүрээнд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн харьяа 3 компанийг татан буулгах, 7 компанийг нэгтгэж 3 болгосон.

Дээрх тогтоол, шийдвэртэй холбоотойгоор бүтэц, зохион байгуулалтаа оновчтой болгон өөрчилж, орон тоогоо тодорхой хувь хэмжээгээр бууруулсан төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагууд Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжийг холбогдох ажилтан, албан хаагчдад олгосон байна.

Засгийн газрын харьяа төсвийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2024-2026 онд хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжид зарцуулсан хөрөнгийн хэмжээ, тэтгэмж олгосон ажилтан, албан хаагчийн тоон мэдээллийг асуулгын хавсралт хүснэгтийн дагуу нэгтгэн хүргүүлж байна.

Харин асуулгын хавсралтад дурдагдсан Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний аудитын газар, Үндэсний статистикийн хороо, Төрийн албаны зөвлөл нь Улсын Их Хурлын харьяа байгууллага тул Засгийн газар эдгээр байгууллагуудын мэдээллийг нэгтгэн гаргах боломжгүй болохыг үүгээр уламжилж байна.

Хавсралт 9 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

**ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХҮҮЛИЙН 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-Т ЗААСАН ҮНДЭСЛЭЛЭЭР
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХАРИЛЦААГ-ЦУЦАЛГАН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧИН-ТОО,
ОЛГОСОН ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ**

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч/ Байгууллагын нэр	2024 он		2025 он		2026 он	
		Тэтгэмж олгосон ажиглан, албан хаагчийн тоо	Олгосон тэтгэмжийн хэмжээ (сая.төг)	Тэтгэмж олгосон ажиглан, албан хаагчийн тоо	Олгосон тэтгэмжийн хэмжээ (сая.төг)	Тэтгэмж олгосон ажиглан, албан хаагчийн тоо	Олгосон тэтгэмжийн хэмжээ (сая.төг)
1	Монгол Улсын Ерөнхий сайд	0	0	0	0	0	0
1.1	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	0	0	0	0	0	0
1.2	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	0	0	0	0	0	0
2	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	3	17.09	9	39.77	3	12.0
2.1	Эдийн засаг, хөгжлийн яам	3	17.09	7	34.47	0	0
2.2	Оюуны өмчийн газар	0	0	0	0	0	0
2.3	Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар	0	0	2	5.30	0	0
2.4	Үндэсний хөгжлийн хүрээлэн	0	0	0	0	3	12.0
3	Монгол Улсын Шадар сайд (Т.Доржханд)	0	0	3	11.26	1	6.15
3.1	Ажлын алба	0	0	0	0	0	0
3.2	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	0	0	0	0	0	0
3.3	Төрийн худалдан авах ажиллагааны газар	0	0	3	11.26	1	6.15
3.4	Монополийн эсрэг газар	0	0	0	0	0	0
4	Монгол Улсын Шадар сайд (Н.Номтойбаяр)	0	0	4	12.26	21	44.85
4.1	Ажлын алба	0	0	0	0	0	0
4.2	Онцгой байдлын ерөнхий газар	0	0	0	0	0	0
4.3	Стандарт, хэмжил зүйн газар	0	0	0	0	0	0

4.4	Аймгийн Стандарт, хэмжил зүйн газар	0	0	1	2.32	20	43.56
4.5	Цагааннуур чөлөөт бүс	0	0	2	3.82	1	1.28
4.6	Алтанбулаг чөлөөт бүс	0	0	1	6.12	0	0
5	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН Хэрэг эрхлэх газрын дарга	0	0	72	266.51	1	14.76
5.1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	0	0	7	31.31	1	14.76
5.2	Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын Үндэсний хорооны ажлын алба (татан буугдсан)	0	0	5	16.61	0	0
5.3	Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны ажлын алба (татан буугдсан)	0	0	13	45.89	0	0
5.4	Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны ажлын алба (татан буугдсан)	0	0	11	42.87	0	0
5.5	20 минутын хот Үндэсний хорооны ажлын алба (татан буугдсан)	0	0	12	45.87	0	0
5.6	Хяналт үнэлгээний Үндэсний хорооны ажлын алба (татан буугдсан)	0	0	9	32.35	0	0
5.7	Алсын хараа 2050 салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны ажлын алба (татан буугдсан)	0	0	10	33.29	0	0
5.8	Эрчим хүчний реформыг удирдан зохион байгуулах Үндэсний хорооны ажлын алба	0	0	5	18.32	0	0
6	Гадаад харилцааны сайд	0	0	0	0	0	0
6.1	Гадаад харилцааны яам	0	0	0	0	0	0
7	Сангийн сайд	0	0	0	0	7	21.02
7.1	Сангийн яам	0	0	0	0	0	0
7.2	Татварын ерөнхий газар	0	0	0	0	0	0
7.3	Гаалийн ерөнхий газар	0	0	0	0	7	21.02
8	Хууль зүй, дотоод хэргийн сайд	1	4.85	18	96.87	2	6.87
8.1	Хууль зүй, дотоод хэргийн яам	0	0	2	21.20	0	0
8.2	Цагдаагийн ерөнхий газар	0	0	0	0	0	0
8.3	Хил хамгаалах ерөнхий газар	0	0	0	0	2	6.87
8.4	Шүүх шинжилгээний ерөнхий газар	0	0	0	0	0	0

8.5	Улсын бүртгэлийн ерөнхий газар	0	0	7	35.32	0	0
8.6	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	0	0	0	0	0	0
8.7	Архивын ерөнхий газар	0	0	3	7.70	0	0
8.8	Гадаадын иргэн, харьяатын газар	0	0	0	0	0	0
8.9	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	1	4.85	6	32.65	0	0
9	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	4	24.66	4	25.60	0	0
9.1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	3	19.39	1	6.98	0	0
9.2	Ашигт малтмал, газрын тосны газар	0	0	3	18.61	0	0
9.3	Үндэсний геологийн алба	1	5.27	0	0	0	0
10	Батлан хамгаалахын сайд	0	0	1	3.156	0	0
10.1	Батлан хамгаалахын яам	0	0	0	0	0	0
10.2	Зэвсэгт хүчний жанжин штаб	0	0	0	0	0	0
10.3	Үндэсний батлан хамгаалах их сургууль	0	0	1	3.16	0	0
11	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	7	34.17	9	32.16	5	17.91
11.1	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	7	34.17	0	0	0	0
11.2	Цаг уур, орчны шинжилгээний газар	0	0	0	0	0	0
11.3	Усны газар	0	0	1	4.62	0	0
11.4	Ойн газар	0	0	0	0	0	0
11.5	Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв	0	0	2	6.48	0	0
11.6	Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газар	0	0	5	18.51	0	0
11.7	Тусгай хамгаалалттай газар	0	0	1	2.55	5	17.91
12	Боловсролын сайд	0	0	0	0	0	0
12.1	Боловсролын яам	0	0	0	0	0	0
12.2	Боловсролын ерөнхий газар	0	0	0	0	0	0
13	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	26	80.82	99	420.43	25	119.46
13.1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	0	0	2	12.90	0	0
13.2	Нийгмийн даатгалын ерөнхий газар	0	0	0	0	0	0
13.3	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	1	2.70	1	7.76	3	19.73
13.4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	0	0	0	0	2	15.43

13.5	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	10	23.53	6	17.97	2	6.00
13.6	"Өнөр бүл" хүүхдийн төв	0	0	0	0	0	0
13.7	Олон Улсын хүүхдийн Найрамдал Цогцолбор	0	0	1	3.27	0	0
13.8	Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн	2	6.51	4	20.98	1	3.77
13.9	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв	0	0	0	0	0	0
13.10	Сэргээн засах, туслах технологийн үндэсний төв	0	0	0	0	1	3.86
13.11	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв	0	0	3	25.44	0	0
13.12	Ахмад настны үндэсний төв	0	0	0	0	0	0
13.13	БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв	0	0	1	21.70	0	0
13.14	Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв	2	29.08	1	24.62	1	29.65
13.15	Аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	0	0	1	1.91	7	16.85
13.16	Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар	11	19.00	24	63.33	2	4.77
13.17	Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	0	0	55	220.55	6	19.40
14	Зам, тээврийн сайд	1	7.93	10	425.22	2	153.59
14.1	Зам, тээврийн яам	0	0	0	0	0	0
14.2	Төмөр замын газар	0	0	3	15.55	1	2.70
14.3	Иргэний нисэхийн ерөнхий газар	1	7.93	7	409.67	1	150.89
15	Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын сайд	1	6.91	7	18.73	22	81.21
15.1	Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын яам	1	6.91	0	0	0	0
15.2	Соёл, урлагийн газар	0	0	0	0	0	0
15.3	Биеийн тамир, спортын улсын хороо	0	0	0	0	0	0
15.4	Чингис хаан үндэсний музей	0	0	3	8.36	0	0
15.5	Богд хааны ордон музей	0	0	1	4.04	0	0
15.6	Монголын Театрын музей	0	0	1	1.56	0	0
15.7	Хүүхдийн төв номын сан	0	0	2	4.77	0	0
15.8	Дуурь бүжгийн Эрдмийн театр	0	0	0	0	11	26.33

15.9	Чингис хааны өв соёлын хүрээлэн	0	0	0	0	11	54.88
16	Хот байгуулалт, барилга, орон сууцнуудын сайд	4	18.27	8	49.07	1	2.97
16.1	Хот байгуулалт, барилга, орон сууцнуудын яам	4	18.27	8	49.07	1	2.97
17	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	1	2.00	0	0	2	11.68
17.1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	0	0	0	0	0	0
17.2	Мал эмнэлгийн ерөнхий газар	0	0	0	0	2	11.68
17.3	Жижиг, дунд үйлдвэрийн газар	1	2.00	0	0	0	0
17.4	Ургамал хамгаалтын газар	0	0	0	0	0	0
18	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	0	0	0	0	0	0
18.1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	0	0	0	0	0	0
18.2	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	0	0	0	0	0	0
19	Эрчим хүчний сайд	0	0	0	0	0	0
19.1	Эрчим хүчний яам	0	0	0	0	0	0
20	Эрүүл мэндийн сайд	0	0	22	74.39	33	118.56
20.1	Эрүүл мэндийн яам	0	0	1	7.32	0	0
20.2	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	0	0	0	0	0	0
20.3	Эм, эмнэлэгтийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	0	0	0	0	1	4.41
20.4	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	0	0	0	0	1	2.35
20.5	Улсын гуравдугаар төв эмнэлэг	0	0	0	0	1	2.23
20.6	Гэмтэл согог судлалын үндэсний төв	0	0	4	17.70	0	0
20.7	Арьсны өвчин судлалын үндэсний төв	0	0	0	0	4	10.49
20.8	Хавдар судлалын үндэсний төв	0	0	1	3.30	0	0
20.9	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	0	0	0	0	7	22.48
20.10	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	0	0	0	0	3	9.67
20.11	Эмгэг судлалын үндэсний төв	0	0	1	1.48	0	0
20.12	Нийслэлийн Түргэн тусламжийн төв	0	0	8	25.25	0	0
20.13	Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв	0	0	2	3.28	0	0
20.14	Наркалогийн эмнэлэг	0	0	0	0	2	6.10

20.15	Амгалан амаржих газар	0	0	1	1.48	1	1.67
20.16	Нийслэлийн эрүүл мэндийн газар	0	0	0	0	2	16.72
20.17	Дорноговь аймгийн Замын-Үүд хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	0	0	0	0	1	1.67
20.18	Завхан аймгийн Уламжлалт анагаах ухааны эмнэлэг	0	0	1	4.24	1	5.52
20.19	Төв аймгийн нэгдсэн эмнэлэг	0	0	2	2.97	1	1.51
20.20	Дархан Уул аймгийн нэгдсэн эмнэлэг	0	0	0	0	2	3.49
20.21	Баянхонгор аймгийн Зооноз өвчин судлалын төв	0	0	0	0	2	8.06
20.22	Дундговь аймгийн Говь-Утгаал сумын эрүүл мэндийн төв	0	0	0	0	1	9.35
20.23	Завхан аймгийн Отгон сумын эрүүл мэндийн төв	0	0	0	0	2	5.22
20.24	Завхан аймгийн Цэцэн-Уул сумын эрүүл мэндийн төв	0	0	0	0	1	7.63
20.25	Ховд аймгийн Зэрэг сумын эрүүл мэндийн төв	0	0	1	7.36	0	0
21	Аймгийн Засаг даргын Тамгын газар	7	36.47	28	70.04	13	42.64
21.1	Архангай аймгийн ЗДТГ	0	0	0	0	0	0
21.2	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	0	0	11	29.12	0	0
21.3	Баянхонгор аймгийн ЗДТГ	0	0	0	0	1	6.16
21.4	Булган аймгийн ЗДТГ	1	1.98	0	0	0	0
21.5	Говь-Алтай аймгийн ЗДТГ	0	0	0	0	0	0
21.6	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	1	21.21	0	0	10	31.31
21.7	Дархан-Уул аймгийн ЗДТГ	0	0	0	0	0	0
21.8	Дорноговь аймгийн ЗДТГ	0	0	0	0	0	0
21.9	Дорнод аймгийн ЗДТГ	0	0	0	0	0	0
21.10	Дундговь аймгийн ЗДТГ	0	0	0	0	0	0
21.11	Завхан аймгийн ЗДТГ	0	0	0	0	0	0
21.12	Орхон аймгийн ЗДТГ	0	0	0	0	0	0
21.13	Өвөрхангай аймгийн ЗДТГ	0	0	0	0	0	0
21.14	Өмнөговь аймгийн ЗДТГ	0	0	0	0	0	0
21.15	Сүхбаатар аймгийн ЗДТГ	3	6.80	2	6.16	0	0

21.16	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	0	0	0	0	0	0	0
21.17	Төв аймгийн ЗДТГ	1	5.27	2	8.64	1	3.32	
21.18	Увс аймгийн ЗДТГ	1	1.20	6	6.76	1	1.86	
21.19	Ховд аймгийн ЗДТГ	0	0	0	0	0	0	
21.20	Хөвсгөл аймгийн ЗДТГ	0	0	7	19.37	0	0	
21.21	Хэнтий аймгийн ЗДТГ	0	0	0	0	0	0	
22	Нийслэл, Дүүргийн Засаг даргын Тамгын газар	0	0	3	8.11	0	0	
22.1	Нийслэлийн ЗДТГ	0	0	0	0	0	0	
22.2	Багануур дүүргийн ЗДТГ	0	0	0	0	0	0	
22.3	Багахангай дүүргийн ЗДТГ	0	0	0	0	0	0	
22.4	Баянгол дүүргийн ЗДТГ	0	0	1	1.28	0	0	
22.5	Баянзүрх дүүргийн ЗДТГ	0	0	0	0	0	0	
22.6	Нагайх дүүргийн ЗДТГ	0	0	1	2.98	0	0	
22.7	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	0	0	0	0	0	0	
22.8	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	0	0	0	0	0	0	
22.9	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	0	0	0	0	0	0	
22.10	Хан-Уул дүүргийн ЗДТГ	0	0	1	3.85	0	0	
23	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд	102	670.53	364	3,033.83	245	3,957.72	
23.1	"МИАТ" ТӨХК	1	31.14	3	206.46	7	430.69	
23.2	"Монголын төмөр зам" ТӨХК	20	155.62	12	165.05	3	52.35	
23.3	"Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК	0	0	7	110.20	14	230.34	
23.4	"Монголын цахилгаан холбоо" ХК	0	0	1	6.00	1	9.45	
23.5	"Төрийн орон сууцны корпораци" ХХК	15	39.98	17	122.19	21	178.40	
23.6	"Автозамын засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК	0	0	19	70.39	2	15.58	
23.7	"Геологийн судалгаа-шинжилгээний төв" ТӨҮГ	2	6.44	2	8.80	0	0	
23.8	"Эрчис ойл" ТӨХХК	0	0	1	65.00	3	17.75	
23.9	"Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ	9	42.38	8	124.38	4	55.50	
23.10	"Автогээврийн үндэсний төв" ТӨҮГ	9	86.67	13	121.20	12	295.40	

23.11	"Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ	0	0	0	0	0	0
23.12	"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ	2	25.35	0	0	0	0
23.13	Улаанбаатар төмөр зам ХНН	4	22.38	1	7.06	24	98.22
23.14	"Мэдээлэл технологийн үндэсний парк" ТӨААТҮГ	0	0	2	77.87	0	0
23.15	"Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨҮГ	6	44.26	10	83.02	3	25.25
23.16	"Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв" ТӨҮГ	0	0	0	0	1	4.00
23.17	"Замын-Үүдийн дулааны станц" ТӨҮГ	-	-	1	4.81	0	0
23.18	"Засгийн газрын авто бааз" ТӨҮГ	12	47.30	10	15.40	7	28.40
23.19	Төрийн банк	0	0	0	0	0	0
23.20	"Монголын хөрөнгийн бирж" ХК	0	0	0	0	0	0
23.21	"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК	0	0	0	0	2	8.45
23.22	"Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК	0	0	0	0	0	0
23.23	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	0	0	0	0	4	510.81
23.24	"Эрдэнэс Монгол" ХХК	0	0	0	0	24	1212.67
23.25	"Эрдмин" ХХК	0	0	0	0	0	0
23.26	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	0	0	9	245.84	0	0
23.27	"Шим технологийн" ХХК	0	0	0	0	0	0
23.28	"Эрдэнэс ойл" ХХК	0	0	0	0	0	0
23.29	"Эрдэнэс оюу толгой" ХХК	0	0	0	0	0	0
23.30	"Монголпроцветмет" ТӨҮГ	1	11.34	20	164.03	92	538.06
23.31	"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК	5	51.13	2	20.79	0	0
23.32	"Эрдэнэс силвер ресурс" ХХК	0	0	0	0	0	0
23.33	"Эрдэнэс алт ресурс" ХХК	10	89.85	8	89.80	1	11.00
23.34	"Эрдэнэс ашид" ХХК	0	0	1	7.00	0	0
23.35	"Эрдэнэс стийл" ХХК	0	0	0	0	0	0
23.36	"Эрдэнэс таван толгой" ХК	0	0	1	43.39	0	0
23.37	"Таван толгой түлш" ХХК	0	0	0	0	0	0

23.38	"Таван толгой ДЦС" ТӨХХК	0	0	0	0	0	0
23.39	"Тавантолгой төмөр зам" ХХК	6	16.69	211	1085.21	1	39.40
23.40	"Багануур" ХК	0	0	0	0	0	0
23.41	"Багануур-Илч" ХХК	0	0	0	0	0	0
23.42	"Монцахим" ХХК	0	0	0	0	0	0
23.43	"Багануур сувилал" ХХК	0	0	0	0	0	0
23.44	"Шивээ овоо" ХК	0	0	2	121.28	1	4.50
23.45	"Шивээ сервис" ХХК	0	0	0	0	0	0
23.46	"Эрдэнэс метан" ХХК	0	0	0	0	1	13.50
23.47	"Метан газ ресурс" ХХК	0	0	0	0	0	0
23.48	"Эрдэнэс шивээ энерги" ХХК	0	0	0	0	0	0
23.49	"Ташуун сүхайт авто зам" ХХК	0	0	0	0	5	49.66
23.50	"Эрдэнэс ассет менеджмент" ХХК	0	0	0	0	0	0
23.51	"Монголын эрдэс баялгийн бирж" ХХК	0	0	0	0	0	0
23.52	"Эрдэнэс газ" төслийн нэгж	0	0	0	0	0	0
23.53	"Эрдэнэс Баянбогд" ХХК	0	0	0	0	0	0
23.54	"Мон-Атом" ХХК	0	0	0	0	1	10.03
23.55	"Бадрах Энержи" ХХК	0	0	0	0	0	0
23.56	"Турван сайхан" ХХК	0	0	0	0	0	0
23.57	"Мон Чех ураниум" ХХК	0	0	0	0	0	0
23.58	"Монголын газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК	0	0	0	0	0	0
23.59	"Чингис хаан УБС" ХХК	0	0	0	0	4	63.71
23.60	"Цөмөнт шохой" ХХК	0	0	3	68.67	7	54.60
Нийт дүн		157	903.70	658	4,579.28	383	4,611.38